| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 197,040,800.00 | 191,899,025.00 | (5,141,775.00)  | 97.4  |
| Гэрэл цахилгаан                                          | 6,726,600.00   | 9,160,793.00   | 2,434,193.00    | 136.2 |
| Түлш, халаалт                                            | 188,114,000.00 | 180,538,232.00 | (7,575,768.00)  | 96.0  |
| Цэвэр, бохир ус                                          | 2,200,200.00   | 2,200,000.00   | (200.00)        | 100.0 |
| Нормативт зардал                                         | 57,803,100.00  | 55,770,375.40  | (2,032,724.60)  | 96.5  |
| Хоол, хүнс                                               | 57,803,100.00  | 55,770,375.40  | (2,032,724.60)  | 96.5  |
| Эд хогшил худалдан авах                                  | 14,000,000.00  | 13,996,000.00  | (4,000.00)      | 100.0 |
| Урсгал засвар                                            | 14,000,000.00  | 13,996,000.00  | (4,000.00)      | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр          | 5,847,900.00   | 4,529,900.00   | (1,318,000.00)  | 77.5  |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,246,800.00   | -              | (1,246,800.00)  | 0.0   |
| Мэдээллийн технологийн зардал                            | 4,601,100.00   | 4,529,900.00   | (71,200.00)     | 98.5  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                          | 37,155,200.00  | 35,887,615.00  | (1,267,585.00)  | 96.6  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                          | 30,253,600.00  | 28,990,900.00  | (1,262,700.00)  | 95.8  |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 6,901,600.00   | 6,896,715.00   | (4,885.00)      | 99.9  |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 72,918,500.00  | 72,199,600.00  | (718,900.00)    | 99.0  |
| Бусад урсгал шилжүүлэг                                   | 72,918,500.00  | 72,199,600.00  | (718,900.00)    | 99.0  |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг                    | 26,786,900.00  | 26,068,000.00  | (718,900.00)    | 97.3  |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж   | 30,133,600.00  | 30,133,600.00  | -               | 100.0 |
| Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж         | 15,998,000.00  | 15,998,000.00  | -               | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 950,799,500.00 | 950,466,300.00 | (333,200.00)    | 100.0 |

Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                                                                                                        |                |                |               |       |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------------|---------------|-------|
| УЛСЫН ТӨСВӨӨС<br>САНХҮҮЖИХ                                                                                             | 653,733,000.00 | 653,733,000.00 | -             | 100.0 |
| Тусгай зориулалтын<br>шилжүүлгээс санхүүжих                                                                            | 653,733,000.00 | 653,733,000.00 | -             | 100.0 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС<br>САНХҮҮЖИХ                                                                                      | 249,688,100.00 | 249,688,100.00 | -             | 100.0 |
| Орон нутгийн төсвөөс                                                                                                   | 249,688,100.00 | 249,688,100.00 | -             | 100.0 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН<br>ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                                                                               | 1,246,800.00   | 913,600.00     | (333,200.00)  | 73.3  |
| Туслах үйл ажиллагааны<br>орлогоос санхүүжих                                                                           | 1,246,800.00   | 913,600.00     | (333,200.00)  | 73.3  |
| Нэмэлт санхүүжилтийн<br>орлого                                                                                         | 46,131,600.00  | 46,131,600.00  | -             | 100.0 |
| Дээд шатны төсвийн<br>захирагчаас төсөвт<br>тусгагдсан төсвөөс доод<br>шатны төсвийн захирагчид<br>хуваарилсан хөрөнгө | 46,131,600.00  | 46,131,600.00  | -             | 100.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах<br>хөрөнгийн эхний үлдэгдэл                                                                    | -              | 0.00           | 0.00          | 0.0   |
| Мөнгө, түүнтэй адилтгах<br>хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                                   | -              | 34,280,656.57  | 34,280,656.57 | 100.0 |
| ТӨСВИЙН БУСАД<br>МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                                                                                    | -              | -              | -             | 0.0   |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО                                                                                                       | -              | -              | -             | 0.0   |
| АЖИЛЛАГСДЫН ТОО                                                                                                        | 38             | 35             | (3)           | 92.1  |
| Удирдах ажилтан                                                                                                        | 1              | 1              | -             | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан                                                                                                      | 24             | 22             | (2)           | 91.7  |
| Үйлчлэх ажилтан                                                                                                        | 13             | 12             | (1)           | 92.3  |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО<br>/жилийн дунджаар/                                                                                  | 521            | 255            | (266)         | 48.9  |

## 2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                                 | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Зөрүү           | Хувь  |
|----------------------------------------------------------|----------------|----------------|-----------------|-------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -              | 0.00           |                 |       |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                     | 654,979,800.00 | 620,365,943.43 | (34,613,856.57) | 94.7  |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                                       | 654,979,800.00 | 620,365,943.43 | (34,613,856.57) | 94.7  |
| Бараа, үйлчилгээний зардал                               | 628,192,900.00 | 594,297,943.43 | (33,894,956.57) | 94.6  |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 468,788,300.00 | 442,257,966.69 | (26,530,333.31) | 94.3  |
| Үндсэн цалин                                             | 358,249,700.00 | 317,247,450.22 | (41,002,249.78) | 88.6  |
| Нэмэгдэл                                                 | 103,336,500.00 | 104,190,528.45 | 854,028.45      | 100.8 |
| Урамшуулал                                               | 7,202,100.00   | 20,819,988.02  | 13,617,888.02   | 289.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 58,598,400.00  | 55,852,086.34  | (2,746,313.66)  | 100.0 |
| Тэтгэврийн даатгал                                       | 39,847,000.00  | 38,430,507.22  | (1,416,492.78)  | 96.4  |
| Тэтгэмжийн даатгал                                       | 4,687,800.00   | 4,506,475.08   | (181,324.92)    | 96.1  |
| ҮОМШӨ ний даатгал                                        | 3,750,300.00   | 3,561,499.93   | (188,800.07)    | 95.0  |
| Ажилгүйдлийн даатгал                                     | 937,600.00     | 848,694.43     | (88,905.57)     | 90.5  |
| Эрүүл мэндийн даатгал                                    | 9,375,700.00   | 8,504,909.68   | (870,790.32)    | 90.7  |
| Нормативт зардал                                         | 57,803,100.00  | 55,770,375.40  | (2,032,724.60)  | 96.5  |
| Хоол, хүнс                                               | 57,803,100.00  | 55,770,375.40  | (2,032,724.60)  | 96.5  |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр          | 5,847,900.00   | 4,529,900.00   | (1,318,000.00)  | 77.5  |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,246,800.00   | -              | (1,246,800.00)  | 0.0   |
| Мэдээллийн технологийн зардал                            | 4,601,100.00   | 4,529,900.00   | (71,200.00)     | 98.5  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                          | 37,155,200.00  | 35,887,615.00  | (1,267,585.00)  | 96.6  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                          | 30,253,600.00  | 28,990,900.00  | (1,262,700.00)  | 95.8  |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 6,901,600.00   | 6,896,715.00   | (4,885.00)      | 99.9  |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 26,786,900.00  | 26,068,000.00  | (718,900.00)    | 97.3  |
| Бусад урсгал шилжүүлэг                                   | 26,786,900.00  | 26,068,000.00  | (718,900.00)    | 97.3  |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг                    | 26,786,900.00  | 26,068,000.00  | (718,900.00)    | 97.3  |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 654,979,800.00 | 654,646,600.00 | (333,200.00)    | 100.0 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                  | 653,733,000.00 | 653,733,000.00 | -               | 100.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                 | 653,733,000.00 | 653,733,000.00 | -               | 0.0   |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                    | 1,246,800.00   | 913,600.00     | (333,200.00)    | 0.0   |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 1,246,800.00   | 913,600.00     | (333,200.00)    | 73.3  |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -              | 0.00           | 0.00            | 0.0   |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -              | 34,280,656.57  | 34,280,656.57   | 0.0   |

Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                    |     |     |       |      |
|------------------------------------|-----|-----|-------|------|
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ   | -   | -   | -     | 0.0  |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО                   | -   | -   | -     | 0.0  |
| АЖИЛЛАГСДЫН ТОО                    | 38  | 35  | (3)   | 0.0  |
| Удирдах ажилтан                    | 1   | 1   | -     | 0.0  |
| Гүйцэтгэх ажилтан                  | 24  | 22  | (2)   | 0.0  |
| Үйлчлэх ажилтан                    | 13  | 12  | (1)   | 92.3 |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 521 | 255 | (266) | 48.9 |

## 2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                          | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Зөрүү          | Хувь  |
|---------------------------------------------------|----------------|----------------|----------------|-------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -              | -              | -              |       |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН              | 249,688,100.00 | 242,257,569.24 | (7,430,530.76) | 97.0  |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                                | 249,688,100.00 | 242,257,569.24 | (7,430,530.76) | 97.0  |
| Бараа, үйлчилгээний зардал                        | 249,688,100.00 | 242,257,569.24 | (7,430,530.76) | 97.0  |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                 | 34,353,100.00  | 32,293,759.22  | (2,059,340.78) | 94.0  |
| Үндсэн цалин                                      | 26,564,400.00  | 26,077,007.75  | (487,392.25)   | 98.2  |
| Нэмэгдэл                                          | 6,460,500.00   | 3,495,179.82   | (2,965,320.18) | 54.1  |
| Урамшуулал                                        | 1,328,200.00   | 2,721,571.65   | 1,393,371.65   | 204.9 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл    | 4,294,200.00   | 4,068,785.02   | (225,414.98)   | 94.8  |
| Тэтгэврийн даатгал                                | 2,920,000.00   | 2,809,062.69   | (110,937.31)   | 96.2  |
| Тэтгэмжийн даатгал                                | 343,600.00     | 327,932.18     | (15,667.82)    | 95.4  |
| ҮОМШӨ ний даатгал                                 | 274,800.00     | 262,345.74     | (12,454.26)    | 95.5  |
| Ажилгүйдлийн даатгал                              | 68,700.00      | 60,858.56      | (7,841.44)     | 88.6  |
| Эрүүл мэндийн даатгал                             | 687,100.00     | 608,585.85     | (78,514.15)    | 88.6  |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал         | 197,040,800.00 | 191,899,025.00 | (5,141,775.00) | 97.4  |
| Гэрэл цахилгаан                                   | 6,726,600.00   | 9,160,793.00   | 2,434,193.00   | 136.2 |
| Түлш, халаалт                                     | 188,114,000.00 | 180,538,232.00 | (7,575,768.00) | 96.0  |
| Цэвэр, бохир ус                                   | 2,200,200.00   | 2,200,000.00   | (200.00)       | 100.0 |
| Эд хогшил худалдан авах                           | 14,000,000.00  | 13,996,000.00  | (4,000.00)     | 100.0 |
| Урсгал засвар                                     | 14,000,000.00  | 13,996,000.00  | (4,000.00)     | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 249,688,100.00 | 249,688,100.00 | -              | 100.0 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                    | 249,688,100.00 | 249,688,100.00 | -              | 100.0 |
| Орон нутгийн төсвөөс                              | 249,688,100.00 | 249,688,100.00 | -              | 100.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -              | -              | -              | 0.0   |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -              | -              | -              | 0.0   |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                  | -              | -              | -              | 0.0   |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО                                  | -              | -              | -              | 0.0   |
| АЖИЛЛАГСДЫН ТОО                                   | 38             | 35             | (3)            | 92.1  |
| Удирдах ажилтан                                   | 1              | 1              | -              | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан                                 | 24             | 22             | (2)            | 91.7  |
| Үйлчлэх ажилтан                                   | 13             | 12             | (1)            | 92.3  |

## 2.8 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт                                                                                                   | Өмнөх он | Гүйцэтгэл     |
|------------|------------------------------------------------------------------------------------------------------------|----------|---------------|
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                           | -        | -             |
| 2          | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                                                                       | -        | 46,131,600.00 |
| 21         | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                                                                                         | -        | 46,131,600.00 |
|            | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                                                           | -        | 46,131,600.00 |
| 2132       | Бусад урсгал шилжүүлэг                                                                                     | -        | 46,131,600.00 |
| 213207     | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                                     | -        | 30,133,600.00 |
| 213208     | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж                                                           | -        | 15,998,000.00 |
|            | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                                                                             | -        | 46,131,600.00 |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                                                                                | -        | 46,131,600.00 |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | -        | 46,131,600.00 |
| 4          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                           | -        | -             |
| 5          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                          | -        | -             |
| 6          | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                                                                           | -        | -             |
| 61         | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                                                                           | -        | -             |
| 62         | АЖИЛЛАГСДЫН ТОО                                                                                            | 38       | 35            |
| 620001     | Удирдах ажилтан                                                                                            | 1        | 1             |
| 620002     | Гүйцэтгэх ажилтан                                                                                          | 24       | 22            |
| 620003     | Үйлчлэх ажилтан                                                                                            | 13       | 12            |
| 63         | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/                                                                         | -        | -             |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022-2023 оны хичээлийн жилд “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тэгш боломж бүрдүүлэх, сурагчдын сонирхолд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг эзэмшүүлэх” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол улсын Бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилгыг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх;
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх;
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх; гэж тодорхойлсон.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 04 дүгээр сарын 2-ний өдөр батлагдсан./
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
  - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.

- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
  - Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал” хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
  - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
  - БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
  - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
  - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
  - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
  - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
  - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”
  6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
  7. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам”-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
  8. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

#### **Байгууллагын дотоод хяналтын талаар**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

#### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,544.2 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна.

#### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------|----------------|-----------------|----------|
|----------|----------------|-----------------|----------|

| Б                                            | 1                  | 2                  | 3=2-1           |
|----------------------------------------------|--------------------|--------------------|-----------------|
| Мөнгөн хөрөнгө                               |                    | 34,280.6           | 34,280.6        |
| Авлага                                       | -                  | 413.1              | 413.1           |
| Бараа материал                               | 66,722.6           | 66,302.3           | (420.3)         |
| Үндсэн хөрөнгө                               | 2,087,738.7        | 2,125,009.5        | 37,270.8        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>2,154,461.3</b> | <b>2,226,005.5</b> | <b>71,544.2</b> |
| Өр төлбөр                                    | 226.7              | 12.0               | (214.7)         |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 2,154,234.6        | 2,225,993.5        | 71,758.9        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>2,154,461.3</b> | <b>2,226,005.5</b> | <b>71,544.2</b> |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа материал, өглөг буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 34,280.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 413.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын авлагыг цалингийн зардлаар бүртгэснийг аудитын явцад залруулсан нь нөлөөлсөн.
3. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 37,270.8 мянган төгрөгөөр нэмэгдэхэд БШУС-ын 2022 оны 170 дугаар тушаалын дагуу БШУЯ-наас 15,280.0 мянган төгрөгийн сурагчийн ширээ, Төв аймгийн БШУГ-аас 9,544.4 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Төв аймгийн Өндөрширээт сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 48,100.0 мянган төгрөгийн биеийн тамирын талбайг тохижуулан, 13,338.0 мянган төгрөгийн газрын хамт хүлээлгэн өгсөн нь нөлөөлсөн байна.
4. Бараа материал өмнөх оноос 420.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 96,779.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 97,199.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Өглөг 214.7 мянган төгрөгөөр буурсан нь хүмүүст өгөх татварын өглөгийг төлснөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 795,393.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 795,393.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 155,406.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 950,799.5 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 42,044.4 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр

654,979.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 249,688.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 1,246.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 620,365.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 242,257.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 913.6 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 7,430.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 908,755.1 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг 41,325.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 718.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д                                   | Хөтөлбөр, арга хэмжээ                                                    | Төлөвлөгөө        | Гүйцэтгэл         | Зөрүү            | Биелэлт      |
|---------------------------------------|--------------------------------------------------------------------------|-------------------|-------------------|------------------|--------------|
| <b>Улсын төсвөөс санхүүжих</b>        |                                                                          |                   |                   |                  |              |
| 1                                     | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ                                         | 1,840.40          | 1,840.40          | -                | 100.00       |
| 2                                     | 80312-Сургалт семинар                                                    | 920.20            | 920.20            | -                | 100.00       |
| 3                                     | 81605-Эрүүл мэндийг дэмжих                                               | 2,116.50          | 2,116.50          | -                | 100.00       |
| 4                                     | 81801-Үдийн цай хөтөлбөр                                                 | 26,786.90         | 26,786.90         | -                | 100.00       |
| 5                                     | 81806-Дотуур байрны үйлчилгээ                                            | 75,218.20         | 75,218.20         | -                | 100.00       |
| 6                                     | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин                                     | 16,485.00         | 16,460.10         | 24.90            | 99.85        |
| 7                                     | 81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх        | 4,141.00          | 4,141.00          | -                | 100.00       |
| 8                                     | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 452,218.20        | 417,962.40        | 34,255.80        | 92.42        |
| 9                                     | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа                                     | 74,006.60         | 74,006.60         | -                | 100.00       |
| 10                                    | 81848-Сурах бичгийн түрээс                                               | 1,246.80          | 913.60            | 333.20           | 73.28        |
| <b>Дүн</b>                            |                                                                          | <b>654,979.80</b> | <b>620,365.90</b> | <b>34,613.90</b> | <b>94.72</b> |
| <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b> |                                                                          |                   |                   |                  |              |
| 1                                     | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал                              | 211,040.80        | 205,895.00        | 5,145.80         | 97.6         |
| 2                                     | 80112-Нийтлэг үйлчилгээ                                                  | 38,647.30         | 36,362.60         | 2,284.70         | 94.1         |
| <b>Дүн</b>                            |                                                                          | <b>249,688.10</b> | <b>242,257.60</b> | <b>7,430.50</b>  | <b>97.0</b>  |
| <b>Нийт дүн</b>                       |                                                                          | <b>904,667.90</b> | <b>862,623.50</b> | <b>42,044.40</b> |              |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 46,131.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3; 43.1.7 дугаар заалтын дагуу нийт 5 багшид хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжид 15,998.0 мянган төгрөгийг, 1 багшид өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмжид 30,133.6 мянган төгрөг, нийт 46,131.6 мянган төгрөгийг олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав..

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургуульд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны батлагдсан нийт зардлын 950,799.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,508.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,655.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 34,280.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан боловч орон нутгийн төсвөөс санхүүждэг гэрэл, цахилгааны зардлыг 2,434.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны old.shilendans.gov.mn цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас 127 мэдээллийг бүрэн байршуулж, 29 мэдээлэл хугацаа хоцроон, 4 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31 удаагийн орлогын 112,729.1 мянган төгрөг, 15 удаагийн зарлагын 133,637.1 мянган төгрөг, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 11 удаагийн 8,553.5 мянган төгрөгийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 156 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 132,177.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 242,749.0 мянган төгрөгөөр буюу 110,572.0 мянган төгрөгөөр илүү, байршуулж, 3 удаагийн 77,272.4 мянган төгрөгийн орлого, 1 удаагийн 5,874.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал гэж заасныг үндэслэн шаардлага өгөв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

2. Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн мэргэжлийн ажилтан бүхий дотоод хяналтын ажлын хэсэгт оруулж, ажиллуулах.

3. Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөөллөөр нийт зардлыг 795,393.4 мянган төгрөгөөр, төсвийг батлахдаа 950,799.5 мянган төгрөгөөр баталж, 908,755.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, улсын төсвийн санхүүжилтээс 34,280.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 7,430.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” 54.5.4-д “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө

оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дүгээр заалтыг мөрдөж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

4. Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 20 иргэн, байгууллагын 15,493.3 мянган төгрөгөөр илүү, 9 иргэн, байгууллагын 2,156.3 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

5. Шалгагдагч байгууллага нь 913.6 мянган төгрөгийн түрээсийн номын орлогыг төлбөрийн баримтын цахим системд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.

6. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг гэрэл цахилгааны зардлыг 2,434.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх " гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал гэж заасныг үндэслэн шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Өндөр ширээт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК гүйцэтгэж, 2 зөвлөмж, 873.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,281.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 601,929.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс 2 актын төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт    |              |           |
|-----------------|------------------------|------------------|------------|--------------|-----------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо        | Дүн          | Хувь      |
| Акт             | 2                      | 873.9            | 2.0        | 873.9        | 100%      |
| Албан шаардлага | 1                      | 2,281.4          | -          | -            | 0%        |
| Зөвлөмж         | 2                      | 601,702.5        | -          | -            | 0%        |
| <b>Нийт дүн</b> | <b>5</b>               | <b>604,857.8</b> | <b>2.0</b> | <b>873.9</b> | <b>0%</b> |

Өмнөх аудитаар дараах зөвлөмж, албан шаардлагаар өгсөн алдаа, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

Зөвлөмж:

1. Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах.
2. Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.

Албан шаардлага:

1. Худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, цахим төлбөрийн баримтаар нотлогдохгүй гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,298,467.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Үүнд: **Залруулсан алдаа:**

- Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 7,430.5 мянган төгрөгийн төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүйг заавар журмын дагуу тайлагнуулсан;
- Нэр данс зөрүүтэй орлого зарлагын нийт 129,032.5 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн орлого зарлагын журналд бүртгээгүйг мөнгөн хөрөнгийн журналд бүртгэсэн;
- Хоолны хэмнэлтийн үлдэгдэлд тогтоосон Төрийн аудитын газрын актын төлбөрийг төлөхдөө тайлант оны хоолны зардлаар бүртгэснийг өмнөх үеийн үр дүнд залруулан бүртгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүйг.
- Тайлант оны цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн цалингийн зөрүү цэсэд 1,463.2 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй, алдааны залруулга, тодруулга гүйлгээг бүртгэснийг анхан шатны баримтын дагуу залруулж бүртгэсэн;
- Тайлант оны 1, 2 дугаар сард нийт 36 ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй, батлагдсан төсөвгүй, 1,496.0 мянган төгрөгийн хоолны нөхөн олговрыг олгосныг суутган залруулсан;
- Тайлант оны 6 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тулгаж шалгахад 1 ажилтны цалин хөлсийг 50.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг нийгмийн даатгалын тайланд залруулсан.
- Төрийн аудитын газрын 2022 оны Дугаар 89-14910520-ТӨА-2022/167/НА-СТА-ТШЗ төлбөр барагдуулах тухай актын дагуу 413.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг тайлант оны цалингийн зардалд бүртгэснийг өмнөх үеийн үр дүнд залруулан бүртгэсэн;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг, ерөнхий журналын цалингийн зардлын дүнтэй тулган шалгахад 1,724.2 мянган төгрөгөөр, гарт олгосон мөнгөн дүн 1,503.9 мянган төгрөгөөр, нийт 3,228.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг анхан шатны баримтыг үндэслэн залруулсан;
- Тайлант оны 1 дүгээр сарын орон нутгийн санхүүжилтээс цалинд шилжүүлсэн дүн, цалингийн олгох батлагдсан хүснэгтийн дүнгээс 432.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн залруулсан;
- Цахилгаан эрчим хүч, халаалтын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүйг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тулган баталгаажуулж залруулсан;
- Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 2,154,461.3 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд тус тус залруулсан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 7,175.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 7,175.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### **Албан шаардлага**

1. Тайлант оны 11, 12 дугаар сарын илүү цагийн дундаж хөлсийг Төрийн албаны Цалингийн нэгдсэн системд тооцохдоо дундаж цалин хөлсөнд нэмэгдэл хөлс, нэг удаагийн шинж чанартай шагнал урамшууллыг оруулан тооцоолж 606 цагийн 6,842.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалын хавсралтын 2.2-т "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно. Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,246.8 мянган төгрөгөөр баталснаас 913.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, төлөвлөгөөг 333.2 мянган төгрөгөөр буюу 26.7 хувиар тасалсан. Түрээсийн номын үнэлгээ жагсаалт тооцоог аудитад ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Орлогын төлөвлөгөөний биелэлтэд тавих, хяналтыг сайжруулж, ажил гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 төрлийн 2,195.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол," гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Байгууллагын нэр дээр ХААН банканд зориулалт тодорхойгүй 57430799564 тоот данс бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д "Банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ." 35.6-д "Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банканд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран батална" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Зориулалт тодорхойгүй дансыг хаах.

## 2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 удгаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах," гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Байгууллагад мөрдөх НБББББ-ийг стандарт, хууль тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж баталж мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга                                                                                                                                                                                                   | Нийт алдаа |           | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |           | Үүнээс     |           |              |  | Зөвлөмж |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------|-----------------------------------|-----|--------------------------|-----------|------------|-----------|--------------|--|---------|-----|
|                                                                                                                                                                                                                     | Тоо        | Дүн       | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн       | Залруулсан |           | Залруулаагүй |  | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 7,430.5 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй байна.                                                                                  | 1          | 7,430.5   |                                   |     | 1                        | 7,430.5   | 1          | 7,430.5   |              |  |         |     |
| Нэр данс зөрүүтэй орлого зарлагын нийт 129,032.5 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн орлого зарлагын журналд бүртгээгүй байна.                                                                               | 1          | 129,032.5 |                                   |     | 1                        | 129,032.5 | 1          | 129,032.5 |              |  |         |     |
| Хоолны хэмнэлтийн үлдэгдэлд бичсэн Төрийн аудитын газрын актын төлбөрийг төлөхдөө тайлант оны хоолны зардлаар бүртгэсэн.                                                                                            | 1          | 460.8     |                                   |     | 1                        | 460.8     | 1          | 460.8     |              |  |         |     |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.                                                                                                                                                  | 1          | -         |                                   |     | 1                        | -         | 1          | -         |              |  |         |     |
| Тайлант оны цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн цалингийн зөрүү цэсэд 1,463.2 мянган төгрөгийн алдааны залруулга, тодруулгыг анхан шатны баримтгүйгээр бүртгэсэн байна.                                            | 1          | 1,463.2   |                                   |     | 1                        | 1,463.2   | 1          | 1,463.2   |              |  |         |     |
| Тайлант оны 1, 2 дугаар сард нийт 36 ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй, батлагдсан төсөвгүй 1,496.0 мянган төгрөгийн хоолны нөхөн олговрыг олгосон байна.                                                | 1          | 1,496.0   |                                   |     | 1                        | 1,496.0   | 1          | 1,496.0   |              |  |         |     |
| Тайлант оны 6 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тулгаж шалгахад 1 ажилтны цалин хөлсийг 50.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.                      | 1          | 50.0      |                                   |     | 1                        | 50.0      | 1          | 50.0      |              |  |         |     |
| Төв аймгийн төрийн аудитын газрын 2022 оны Дугаар 89-14910520-ТӨА-2022/167/НА-СТА-ТШЗ төлбөр барагдуулах тухай актын дагуу 413.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг цалингийн зардалд бүртгэсэн байна.                  | 1          | 413.1     |                                   |     | 1                        | 413.1     | 1          | 413.1     |              |  |         |     |
| Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 1,724.2 мянган төгрөгөөр, гарт олгосон мөнгөн дүн 1,503.9 мянган төгрөгөөр, нийт 3,228.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1          | 3,228.2   |                                   |     | 1                        | 3,228.2   | 1          | 3,228.2   |              |  |         |     |

Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |           |                    |          |                    |           |                  |           |                    |  |  |  |  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|--------------------|----------|--------------------|-----------|------------------|-----------|--------------------|--|--|--|--|
| 2022 оны 1 сарын орон нутгийн санхүүжилтээр олгосон цалин цалингийн олгох батлагдсан хүснэгтээс 432.2 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | 1         | 432.2              |          |                    | 1         | 432.2            | 1         | 432.2              |  |  |  |  |
| Цахилгаан эрчим хүч, халаалт бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 1         | -                  |          |                    | 1         | -                | 1         | -                  |  |  |  |  |
| Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 2,154,461.3 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулаагүй байна. | 1         | 2,154,461.3        | 1        | 2,154,461.3        |           |                  | 1         | 2,154,461.3        |  |  |  |  |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | <b>12</b> | <b>2,298,467.9</b> | <b>1</b> | <b>2,154,461.3</b> | <b>11</b> | <b>144,006.6</b> | <b>12</b> | <b>2,298,467.9</b> |  |  |  |  |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Нийт зөрчил |                | Үүнээс        |          |                 |                |          |          |                                      |                     |                                                 |          |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|----------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|----------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |             |                | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн      | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн      |
| Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,246.8 мянган төгрөгөөр баталснаас 913.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж төлөвлөгөөг 333.2 мянган төгрөгөөр буюу 26.7 хувиар тасалсан. Түрээсийн номын үнэлгээ жагсаалт тооцоог аудитад ирүүлээгүй.                                                                                                                | 1           | 333.2          |               |          | 1               | 333.2          |          |          |                                      |                     |                                                 |          |
| Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.                                                                                                                                                                                              | 1           | -              |               |          |                 |                | 1        | -        |                                      |                     |                                                 |          |
| Байгууллагын нэр дээр ХААН банканд зориулалт тодорхойгүй 57430799564 тоот данс бүртгэлтэй байна.                                                                                                                                                                                                                                                                     | 1           | -              |               |          |                 |                | 1        | -        |                                      |                     |                                                 |          |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 төрлийн 2,195.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.                                                                                                                                                                                                                                                                         | 1           | -              |               |          | 1               | -              |          |          |                                      |                     |                                                 |          |
| Тайлант оны 11, 12 дугаар сарын илүү цагийн дундаж хөлсийг Төрийн албаны Цалингийн нэгдсэн системд тооцохдоо дундаж цалин хөлсөнд нэмэгдэл хөлс, нэг удаагийн шинж чанартай шагнал урамшууллыг оруулан тооцоолж 606 цагийн 6,842.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон байна. Энэ нь төсвийг үр ашигтай хэмнэлттэй байх зарчимтай нийцэхгүй байна. | 1           | 6,842.5        |               |          | 1               | 6,842.5        |          |          |                                      |                     |                                                 |          |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | <b>5</b>    | <b>7,175.7</b> | <b>0</b>      | <b>0</b> | <b>3</b>        | <b>7,175.7</b> | <b>2</b> | <b>-</b> | <b>0</b>                             | <b>0</b>            | <b>0</b>                                        | <b>-</b> |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Нийт зөрчил |                  | мянган төгрөгөөр |                 |          |                  |            |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|------------------|------------------|-----------------|----------|------------------|------------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |             |                  | Үүнээс           |                 | Зөвлөмж  |                  |            |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Тоо         | Дүн              | Төлбөрийн акт    | Албан шаардлага | Тоо      | Дүн              | Тоо Дүн    |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |             |                  |                  |                 |          |                  |            |
| Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны old.shilendans.gov.mn цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас 127 мэдээллийг бүрэн байршуулж, 29 мэдээлэл хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31 удаагийн орлогын 112.7 мянган төгрөг, 15 удаагийн зарлагын 133,637.1 мянган төгрөг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 11 удаагийн 8,553.5 мянган төгрөгийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна. | 1           | 254,919.7        |                  |                 | 1        | 254,919.7        |            |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | <b>1</b>    | <b>254,919.7</b> |                  |                 | <b>1</b> | <b>254,919.7</b> |            |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |             |                  |                  |                 |          |                  |            |
| 2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.                                                                                                                                                                | 1           | -                |                  |                 |          | 1                | -          |
| Орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг гэрэл цахилгааны зардлыг 2,434.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 1           | 2,434.2          |                  |                 | 1        | 2,434.2          |            |
| Гүйцэтгэлд суурилсан төсвийг цөөн нэр төрлөөр баталснаас шалтгаалж, тээвэр шатахуун, томилолт, сургалт, хөрөнгө бэлтгэх зэрэг зардлуудыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зардлын ангилал, дансдаар ангилж бүртгээгүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр тайлагнаагүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | 1           | -                |                  |                 | 1        | -                |            |
| Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөөллөөр нийт зардлыг 795,393.4 мянган төгрөгөөр, төсвийг батлахдаа 950,799.5 мянган төгрөгөөр баталж, 908,755.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, улсын төсвийн санхүүжилтээс 34,280.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 7,430.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 1           | 42,011.2         |                  |                 |          |                  | 1 42,011.2 |
| Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 1           | 17,649.5         |                  |                 | 1        | 17,649.5         |            |

|                                                                                                                                                      |          |                  |  |  |          |                  |          |                 |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|------------------|--|--|----------|------------------|----------|-----------------|
| системд бүртгэсэн дүнтэй тулгахад 20 иргэн, байгууллагын 15,493.3 мянган төгрөгөөр илүү, 9 иргэн, байгууллагын 2,156.3 мянган төгрөгөөр дутуу байна. |          |                  |  |  |          |                  |          |                 |
| Шалгагдагч байгууллага нь 913.6 мянган төгрөгийн түрээсийн номын орлогыг төлбөрийн баримтын цахим системд бүртгээгүй байна.                          | 1        | 913.6            |  |  |          |                  | 1        | 913.6           |
| <b>Дүн</b>                                                                                                                                           | <b>6</b> | <b>63,008.5</b>  |  |  | <b>3</b> | <b>20,083.7</b>  | <b>3</b> | <b>42,924.8</b> |
| <b>Нийт дүн</b>                                                                                                                                      | <b>7</b> | <b>317,928.2</b> |  |  | <b>4</b> | <b>275,003.4</b> | <b>3</b> | <b>42,924.8</b> |